



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/109

Биндэр сум

**Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх
ажил зохион байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Онон багийн нутаг Яргуйн хавцал, Элсэн даваа, Аранжамба, Бага Шаазгай, Өргөн нарс, Намын давааны өвөр, Мандалхаан багийн нутаг Тусгал, Өвөр хүүрт, Дархинт зэрэг газруудын ойн санд улсын төсвийн хөрөнгөөр 1000 га талбайд ойн хөнөөлт шавж өрөөсгөл хүр эрвээхэйтэй тэмцэх ажлыг 2026 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс 07 дугаар сарын 14-ны өдөр хүртэл бактерийн бэлдмэлээр агаараас дроноор хийж гүйцэтгэх тул дээрх хугацаанд эдгээр газруудаар зорчих, ургамал түүж бэлтгэх, мал, зөгий бэлчээрлүүлэх, аялах, зугаалах, бусад үйл ажиллагаа явуулахыг түр хугацаагаар хориглосугай.

2.Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын мэдээллийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөлүүдэд сурталчлан таниулж ажиллахыг байгаль хамгаалагч (Т.Нарангарав), (Н.Болор-Эрдэнэ) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг зохион байгуулах, хяналт тавьж ажиллахыг "Биндэр-Ой" сум дундын ойн ангийн дарга (О.Сүхбат), "Биндэр-Ой" сум дундын ойн ангийн инженер (Э.Сайханжаргал) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН

